

“ТАВАНТОЛГОЙ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2024 оны 08 сарын 26 өдөр

Өмнөговь аймаг

“Тавантолгой” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал 2024 оны 08 сарын 26-ны өдрийн 11:00 цагт Өмнөговь аймгийн Цогтцэций сум, “Тавантолгой” ХК-ийн байрны хурлын танхимд эхлэв.

Хурлын ирц:

Хурлын дэгийн дагуу 11:20 хүртэл ирц бүртгэсэн.

Тооллогын комиссын дарга Б.Онон-н танилцуулснаар:

Компанийн 50,195,811 ширхэг хувьцааг эзэмшиж буй 13 хувьцаа эзэмшигч хуралд оролцож байгаа нь нийт саналын эрхтэй 52,665,200 ширхэг энгийн хувьцааны 95.31% болж байна. Иймд “Компанийн тухай” хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1, 69.2 дах заалтыг үндэслэн хурлын ирцийг хүчин төгөлдөрт тооцов.

Хурлын дарга Г.Цог-Өрнөх хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг нээж үг хэлсний дараа хурлын дэг, хэлэлцэх асуудлуудыг танилцуулав. Үүнд:

- 1) Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд тодотгол хийж, төрийн аудитын байгууллагад мэдээлсэн тухай танилцуулга,
- 2) Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд тодотгол хийж, төрийн аудитын байгууллагад мэдээлсэн тухай Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэх,
- 3) Компанийн 2023 оны ногдол ашиг хуваарилахтай холбоотой Төлөөлөн Удирдах Зөвлөлийн тогтоолыг хэлэлцэх,
- 4) Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах,

Үүний дараа ээлжит бус хурлын зохион байгуулалт, хувьцаа эзэмшигчдийг төлөөлөн хуралд оролцож буй оролцогчид болон мэргэжлийн байгууллагын төлөөллүүдийг танилцуулав.

“Тавантолгой” ХК -ийн Гүйцэтгэх захирал Ч.Гүнждагва компанийн үйл ажиллагаа, борлуулалтын нөхцөл байдал, санхүүгийн үр дүнгийн талаар танилцуулгыг хувьцаа эзэмшигчдийн төлөөлөлд танилцуулав.

Хэлэлцсэн нь:

1. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд тодотгол хийж, төрийн аудитын байгууллагад мэдээлсэн тухай танилцуулга

Хурлын дарга Г.Цог-Өрнөх компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд төрийн аудитын байгууллагаас ирүүлсэн зөвлөмжийн үндсэн дээр тодотгол хийж тайлагнах хүрээнд компани болон Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар дэлгэрэнгүй танилцуулж, асууж тодруулах зүйл байвал нээлттэй хандахыг хүсэв.

Хувьцаа эзэмшигчдийн төлөөллийн зүгээс компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн үр дүнгийн талаар зарим зүйлсийг тодруулж, хариуцсан албан тушаалтнуудаас хариулт тайлбар авав.

2. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд тодотгол хийж, төрийн аудитын байгууллагад мэдээлсэн тухай Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэх

“Тавантолгой” ХК -ийн Захиргаа, Санхүү удирдлагын газрын дарга компанийн 2023 үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн ТУЗ-ийн дүгнэлтийг танилцуулж, тодруулга асуултуудад бүрэн мэдээлэл, хариулт өгөв.

Хувьцаа эзэмшигч С.Пүрэвжав компанийн санхүүгийн нөхцөл байдал, олон нийтэд нээлттэй байршуулсан санхүүгийн тайлн, үр дүнгийн талаар тодруулж, зохих хариултыг авав.

3. Компанийн 2023 оны ногдол ашиг хуваарилахтай холбоотой Төлөөлөн Удирдах Зөвлөлийн тогтоолыг хэлэлцэх

Хурлын дарга Г.Цог-Өрнөх компанийн 2023 оны ногдол ашгийг хуваарилах, шинэчлэн тогтоох тухай Төлөөлөн Удирдах Зөвлөлийн шийдвэрийг хувьцаа эзэмшигчдэд уншиж танилцуулав.

Ногдол ашгийн талаарх шийдвэртэй холбоотойгоор орон нутгийн өмчийн төлөөлөл ногдол ашгийн хэмжээг нэмэгдүүлэх, нийт цэвэр ашгийн 90%-д хүргэхээр саналаа илэрхийлж, холбогдох хууль тогтоомж, эрх хэмжээний хүрээнд хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэх боломжгүй талаар хариулт авав.

Хуралд оролцсон бусад хувьцаа эзэмшигчдийн зүгээс зохих санал, сэтгэгдлээ илэрхийлэв.

4. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах

Хурлын дарга компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын хүрээнд Төлөөлөн Удирдах Зөвлөлийг шинэчлэн томилох шаардлага, үндэслэлийг хувьцаа эзэмшигчдэд танилцуулж, “Тавантолгой” ХК-ийн Захиргаа, Санхүү удирдлагын газрын захирал Ч.Төрмандах ТУЗ-д нэр дэвшихээр хүсэлт ирүүлсэн нэр дэвшигчдийг танилцуулж, мэдээлэл хүргэв. Нэр дэвшигчдийн мэдээлэл:

Ердийн гишүүнд нэр дэвшигч:

- Сүрэнхүүгийн Мятавдорж
- Бямбаагийн Мэндбаяр

- Шаравын Отгонбаяр
- Эрдэнэчулууны Бөхбат
- Дашдэмбэрэлийн Бат-Эрдэнэ
- Цэнд-Аюушийн Цэнгэлбаяр

Хараат бус гишүүнд нэр дэвшигч

- Галсандоржийн Цог-Өрнөх
- Лхачингийн Батчулуун
- Даваадоржийн Дэлгэрцогт

Санал хураалт:

Хурлаар хэлэлцэх асуудлуудыг хэлэлцүүлсний дараа тооллогын комиссын дарга Б.Онон санал хураалт эхэлж буйг мэдэгдэж, хэлэлцэж байгаа нийт 4 асуудлын 3-д нь ердийн аргаар, 1 асуудал буюу ТУЗ-ийн гишүүдийг сонгох асуудалд кумулятив аргаар санал хураахыг дурдав.

Санал хураалт явагдаж дуусав.

Тооллогын комиссын дарга Б.Онон санал хураалтын дүнг танилцуулав.

Хурлаар дараах асуудлуудыг ердийн аргаар санал хураан шийдвэрлэв.

1. **Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд тодотгол хийж, төрийн аудитын байгууллагад мэдээлсэн тухай танилцуулга:**

Зөвшөөрсөн – 50,195,811 ширхэг хувьцаа буюу 100%

Татгалзсан - 0 ширхэг хувьцаа буюу 0%

Түдгэлзсэн - 0 ширхэг хувьцаа буюу 0%

2. **Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд тодотгол хийж, төрийн аудитын байгууллагад мэдээлсэн тухай Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэх:**

Зөвшөөрсөн – 50,195,811 ширхэг хувьцаа буюу 100%

Татгалзсан - 0 ширхэг хувьцаа буюу 0%

Түдгэлзсэн - 0 ширхэг хувьцаа буюу 0%

3. **Компанийн 2023 оны ногдол ашиг хуваарилахтай холбоотой Төлөөлөн Удирдах Зөвлөлийн тогтоолыг хэлэлцэх:**

Зөвшөөрсөн – 50,195,811 ширхэг хувьцаа буюу 100%

Татгалзсан – 0 ширхэг хувьцаа буюу 0%

Түдгэлзсэн - 0 ширхэг хувьцаа буюу 0%

4. **Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах:**

Саналын хуудсаар "Тавантолгой" ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох тухай асуудлаар хуралд оролцсон саналын эрхтэй нийт хувьцаа эзэмшигчдийн өгсөн саналын дүн:

Ердийн гишүүдэд өгсөн санал:

№	ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигчдийн нэрс	Саналын хувь	Кумулятив аргаар өгсөн саналын тоо
1	Сүрэнхүүгийн Мятавдорж	11.351%	46,916,123.00
2	Бямбаагийн Мэндбаяр	11.708%	48,389,153.00
3	Шаравын Отгонбаяр	11.708%	48,389,153.00
4	Эрдэнэчулууны Бөхбат	11.708%	48,389,153.00
5	Дашдэмбэрэлийн Бат-Эрдэнэ	11.362%	46,961,878.00
6	Цэнд-Аюушийн Цэнгэлбаяр	12.479%	51,578,813.00

Хараат бус гишүүдэд өгсөн санал:

№	ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигчдийн нэрс	Саналын хувь	Кумулятив аргаар өгсөн саналын тоо
1	Галсандоржийн Цог-Өрнөх	11.708%	48,389,153.00
2	Лхачингийн Батчулуун	11.708%	48,389,153.00
3	Даваадоржийн Дэлгэрцогт	6.269%	25,910,613.00

тус тус санал авч эдгээр гишүүд ТУЗ-ийн гишүүдэд сонгогдов.

Санал хураалтын дүнг танилцуулсны дараа Хурал даргалагч тухайн хурлаас гарч буй шийдвэр, санал хураалтын дүнг хувьцаа эзэмшигчид хүлээн зөвшөөрч, санал нийлж байгаас эсэх, батлах эсэхийг тодруулав. Хувьцаа эзэмшигчид ээлжит бус хурлын санал хураалтын тооллогын дүн, хурлаас гарч буй шийдвэрийг хүлээн зөвшөөрч байгаагаа илэрхийлж, бүрэн гар өргөж баталгаажуулав.

Хувьцаа эзэмшигчдийн зүгээс шинээр томилогдож буй Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг биетээр танилцуулахыг хүсэж, Хурал даргалагч шинээр сонгогдож буй гишүүдийг нэг бүрчлэн индэрийн өмнө урьж танилцуулан, холбогдох тодруулгуудад хариулт өгөв.

Хурлын дарга хурлыг хааж үг хэлснээр хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал 14:05 минутанд өндөрлөв.

Хурлын шийдвэр:

1. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд тодотгол хийж, төрийн аудитын байгууллагад мэдээлсэн тухай танилцуулга:

1.1 "Тавантолгой" ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд тодотгол хийж, төрийн аудитын байгууллагад мэдээлсэн тухай хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулсныг тэмдэглэсүгэй.

- 1.2 “Тавантолгой” ХК-ийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийгдсэн тодотголын хүрээнд зохих арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Төлөөлөн Удирдах Зөвлөл, Гүйцэтгэх удирдлагад даалгасугай.
2. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд тодотгол хийж, төрийн аудитын байгууллагад мэдээлсэн тухай Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай:
- 2.1 “Тавантолгой” ХК-ийн 2023 үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд тодотгол хийж, төрийн аудитын байгууллагад мэдээлсэн тухай Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Дүгнэлтийг баталсугай.
- 2.2 Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг цаашид бодлого шийдвэртээ тусгаж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөл, Гүйцэтгэх удирдлагад даалгасугай.
3. Компанийн 2023 оны ногдол ашиг хуваарилах тухай Төлөөлөн Удирдах Зөвлөлийн тогтоолыг хэлэлцэх тухай:
- 3.1 “Тавантолгой” ХК-ийн 2023 оны ногдол ашиг хуваарилах тухай Төлөөлөн Удирдах Зөвлөлийн тогтоолын хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд танилцуулсныг тэмдэглэсүгэй.
- 3.2 Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан шийдвэрийн дагуу ногдол ашиг хуваарилах, хувьцаа эзэмшигчдэд бүрэн олгох асуудлыг зохион байгуулахыг Гүйцэтгэх удирдлагад үүрэг болгосугай.
4. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг томилох тухай:
- 6.1 “Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн, хараат бус гишүүдийг санал хураах кумулятив аргыг ашиглан дараах бүрэлдэхүүнтэйгээр сонгосугай. Үүнд:
1. Сүрэнхүүгийн Мятавдорж /ердийн гишүүн/
 2. Бямбаагийн Мэндбаяр /ердийн гишүүн/
 3. Шаравын Отгонбаяр /ердийн гишүүн/
 4. Эрдэнэчулууны Бөхбат /ердийн гишүүн/
 5. Дашдэмбэрэлийн Бат-Эрдэнэ /ердийн гишүүн/
 6. Цэнд-Аюушийн Цэнгэлбаяр /ердийн гишүүн/
 7. Галсандоржийн Цог-Өрнөх /хараат бус гишүүн/
 8. Лхачингийн Батчулуун /хараат бус гишүүн/
 9. Даваадоржийн Дэлгэрцогт /хараат бус гишүүн/
- 6.2 Шинээр сонгогдсон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг хууль тогтоомжийн дагуу идэвхи санаачлагатай ажиллахыг үүрэг болгосугай.

Тэмдэглэл хөтөлсөн:



/Н.Адъяацэрэн/
ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

Тэмдэглэл хянасан:



/Г.Цог-Өрнөх/
Хурал даргалагч